

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн хүн амын хаврын улирлын махны хангамжийг тогтвортой, хүртээмжтэй хангах зорилгоор мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэрийн нөөцийн мах бэлтгэхэд дэмжлэг, урамшуулал олгох, хяналт тавих, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 1.2.1 “малчин” гэснийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д зааснаар;
- 1.2.2 “төлбөрийн баримт” гэснийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-т зааснаар;
- 1.2.3 “бүртгэлийн систем” гэснийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18-д зааснаар;
- 1.2.4 “бэлтгэлийн мал, амьтан” гэснийг Мал нядлах үйлдвэр. Аюулын дүн шинжилгээ ба эгзгийг хянах цэгийн (НАССР) тогтолцооны загвар. MNS 5998:2009 стандартын 3.20-д зааснаар;

1.3 Бэлтгэлийн малд тавих мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан заавар, журмаар тогтооно.

1.4 Урамшууллын тооцооллыг боловсруулах үндсэн суурь мэдээллийг тухайн мэдээлэл бүртгэлтэй албан ёсны төрийн байгууллагуудаас холбогдох хууль, журмын хүрээнд гэрээ байгуулан мэдээллийн эх үүсвэрийг цахим хэлбэрээр солилцоно. Үүнд:

- 1.4.1 Малчин, мал бүхий этгээдэд бүртгэлтэй малын тооллогын дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны мал, тэжээвэр амьтдын жил тутмын тооллогын мэдээллээс;
- 1.4.2 Төлбөрийн баримтын мэдээллийг Татварын ерөнхий газар, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн мэдээллээс;
- 1.4.3 Санхүүгийн болон татварын тайланг Сангийн яам, Татварын ерөнхий газрын мэдээллээс;
- 1.4.4 Мал эмнэлгийн гэрчилгээний мэдээллийг Мал эмнэлгийн ерөнхий газрын цахим системээс;
- 1.4.5 Бусад шаардлагатай мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудын зохих мэдээллээс;

1.5 Энэхүү журмыг харьяалах нутаг дэвсгэртээ сурталчлах, малчдад сургалт явуулах ажлыг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн байгууллагууд, үйлдвэрлэгчидтэй хамтран зохион байгуулна.

Хоёр. Малчин, мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэрт тавих шаардлага, сонгон шалгаруулалт, урамшуулал олгох харилцаа

2.1 Нөөцийн мах бэлтгэх мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэрт амьд мал нийлүүлэх малчин нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна;

2.1.1 Үндэсний статистикийн хорооны мал, тэжээвэр амьтдын жил тутмын тооллогын мэдээллийн санд мал сүргээ үүлдэр, омог, хээлтэгч, хээлтүүлэгчээр нь ялган бүртгүүлсэн байх;

2.1.2 Мал, амьтны халдварт, зооноз өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх хөтөлбөрт мал сүргээ бүрэн хамруулж, Мал эмнэлгийн ерөнхий газрын цахим системд бүртгүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ авсан байх;

2.1.3 Мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэрт малаа худалдан борлуулсан тухай бүр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.13-т заасан төлбөрийн баримтыг үйлдэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд баталгаажуулсан байх;

2.1.4 Мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэртэй сүүлийн хоёр жилийн хугацаанд бэлтгэн нийлүүлэх, гэрээ байгуулсан байх;

2.1.5 Бусад;

2.2. Мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэр нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

2.2.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан үйл ажиллагааны дүгнэлттэй байх;

2.2.2. Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасан стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх;

2.2.3. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын хуудсаар үйл ажиллагаа нь хангалттай түвшинд дүгнэгдсэн байх;

2.2.4. Мах боловсруулах үйлдвэр нь мал төхөөрөх үйлдвэртэй хамтран ажиллах гэрээ байгуулсан байх;

2.2.5. Шаардлагатай тохиолдолд мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэр нь стандартын шаардлага хангасан гүн хөлдөөх (-35⁰С температурт, 10 тн доошгүй багтаамжтай), хөргөлттэй (-18⁰С ихгүй температурт) агуулах бүхий аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан байх;

2.2.6. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.7.5-д заасны дагуу үйлдвэрийн гүн хөлдөөх (-35⁰С температурт, 10 тн доошгүй багтаамжтай), хөргөлттэй (-18⁰С ихгүй температурт) агуулах, орчин, тээврийн хэрэгсэл, тээвэрлэлтэд хэрэглэсэн тоног төхөөрөмжийг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр халдваргүйтгэл хийлгэсэн тухай акттай байх;

2.2.7. Сүүлийн хоёр жилийн санхүүгийн болон татварын тайланг баталгаажуулсан байх;

2.2.8. Хүнсний зориулалтаар халдварт, зооноз өвчний халдварт өртөөгүй сүргээс эмнэл зүйн хувьд эрүүл, дундаас дээш тарга хүчтэй малыг бэлтгэсэн байх;

2.2.9. Малчнаас амьд мал худалдан авах бүр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.13-т заасан төлбөрийн баримтыг үйлдэн татварын цахим төлбөрийн баримтын системд бүртгэж, баталгаажуулсан байх;

2.2.10. Бусад;

2.3 Нөөцийн мах бэлтгэх арга хэмжээнд оролцох мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэрийг сонгон шалгаруулах, махны нөөц бүрдүүлэлт, түүний явц, чанар, аюулгүй байдал, худалдаалалтад хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/-ийг нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулна.

2.4 Мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэр нь энэхүү журмын 2.2.1-2.2.10-д заасан шаардлагыг хангасан баримт бичиг, албан бичгийн хамт Ажлын хэсэгт ирүүлнэ.

2.5 Ажлын хэсэг нөөцийн мах бэлтгэх арга хэмжээнд оролцох мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэрийн сонгон шалгаруулалтыг хийнэ.

2.6 Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлтээ ирүүлсэн мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэрийн баримт бичгийг хянан урамшуулалд хамрагдах үйлдвэрийн жагсаалтыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулна.

2.7 Нөөцийн махыг арилжааны банкны эх үүсвэрээр, зээлийн хүүгийн хөнгөлөлт буюу татаас өгөх хэлбэрээр урамшууллыг олгож болно.

2.8 Ажлын хэсэг мал, мах бэлтгэхтэй холбогдсон тооцоо, судалгаа эсхүл үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулж, шийдвэрлүүлэх замаар урамшуулал олгох асуудлыг зохион байгуулж болно.

Гурав. Урамшууллын төлбөр тооцоо

3.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч урамшуулалд шаардагдах эх үүсвэрийн талаарх саналыг холбогдох тооцоо, судалгаа, шаардлагатай бусад баримт бичгийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж батлуулна.

3.2 Үйлдвэр нь малчнаас амьд мал худалдан авах тухай бүр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.13-т заасан төлбөрийн баримтыг үйлдэн татварын цахим төлбөрийн баримтын системд бүртгэн тухай бүр тухайн бүтээгдэхүүнийг худалдсан, худалдан авсан хоёр тал тооцоо нийлж баталгаажуулсан байна.

3.3 Журмын 2.7 дахь заалтыг үндэслэн банктэй холбогдох гэрээ байгуулж, гэрээний дагуу нөөцийн мах бэлтгэсэн мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэрт урамшууллын нэхэмжлэлийг үндэслэн банкинд шилжүүлнэ.

Дөрөв. Хяналт, тайлан бүртгэл

4.1 Нөөцийн мах бэлтгэлийн ажлыг 8 дугаар сарын 01-ний дотор эхлүүлж, махны нөөц бүрдүүлэлтэд ажлын хэсэг хяналт тавина.

4.2 Ажлын хэсэг урамшуулалд хамрагдах шаардлага хангасан мал төхөөрөх үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэрийн зээл олгогдох боломжит мөнгөн дүн, бэлтгэх махны хэмжээ, зээлийн олголтын явц, түүний үр дүн болон холбогдох мэдээллийг хүнсний асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллагад 8 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.

4.3 Ажлын хэсэг нөөцийн махны бүрдүүлэлт, түүний явц, чанар, аюулгүй байдал, нийлүүлэлт, худалдаалалтын талаарх мэдээллийг 7 хоног тутамд хүнсний асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

4.4 Ажлын хэсэг урамшуулалд шаардагдах хөрөнгийн зарцуулалт, урамшууллын санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж, аудит хийлгүүлэх ажлыг зохион байгуулна.

4.5 Урамшууллын зарцуулалтад Төсвийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.3-т заасны дагуу дотоод аудитын асуудал хариуцсан нэгж нь 2 жил тутамд 1 удаа, шаардлагатай бол удирдлагын шийдвэрээр тухай бүр дотоод аудит хийнэ.

4.6 Нөөцийн махыг татварын цахим системд баталгаажсан баримтад үндэслэн худалдан борлуулахыг нийслэлийн Татварын газар хариуцан гүйцэтгэнэ.

4.7 Нөөцийн махны нийлүүлэлт, түгээлт, борлуулалтын үе шатанд чанар, аюулгүй байдалд Мэргэжлийн хяналт болон Мал эмнэлгийн байгууллага хяналт тавина.

Тав. Хариуцлага

5.1 Малчин, мал төхөөрөх болон мах боловсруулах үйлдвэр, мал эмнэлгийн нэгж, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичиг, мэдээллийн үнэн зөвийг тухайн ирүүлсэн этгээд бүрэн хариуцна.

5.2 Энэхүү журамд заасан баримт бичиг, мал эмнэлгийн гэрчилгээ, татварын цахим төлбөрийн баримтыг холбогдох журмыг зөрчиж хуурамчаар бүрдүүлснийг эрх бүхий байгууллагаас тогтоосон, хуурамч болох нь илт тодорхой байтал түүнийг хянаж баталгаажуулан урамшуулалд хамруулахыг завдсан буюу хамруулсан, төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх ба үүнтэй холбоотойгоор үүссэн хохирлыг буруутай этгээд хариуцна.

5.3 Холбогдох мэдээлэл буруу, бүртгэл дутуу байдлаас шалтгаалан урамшуулал олгогдоогүй тохиолдолд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч хариуцлага хүлээхгүй.

....oo00oo....